



Европын Холбоо
санхүүжүүлэв



Food and Agriculture
Organization of the
United Nations



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



UN
DP

ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ "МОНГОЛ УЛСАД
ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТ ОЙ УЯЛДСАН ТӨСВИЙН
ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ
ДЭМЖИХ НЬ" ТӨСӨЛ

СОЁЛЫН САЛБАРЫН

2023 ОНЫ ТӨСВИЙН ЗАРЛАГА БОЛОН ҮР
ДҮНГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/СОЁЛ УРЛАГ ХӨТӨЛБӨР/

2024 он

ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ “МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТОЙ УЯЛДСАН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ

СОЁЛ УРЛАГИЙН САЛБАРЫН 2023 ОНЫ ТӨСВИЙН ЗАРЛАГА БОЛОН ҮР ДҮНГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Тайланг боловсруулсан:

Ж.Ганбаатар, НҮБХХ-ийн зөвлөх

Соёлын яамны санхүү, хөрөнгө оруулалтын газар

Хянан тохиолдуулсан:

М.Санжаадорж, Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга

Ж.Отгонбат, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга

Энэхүү “Соёлын салбарын 2023 оны төсвийн зарлагын болон үр дүнгийн гүйцэтгэлийн тайлан”-г “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд боловсруулав. Төслийг Европын Холбооны санхүүжилтээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран хэрэгжүүлдэг.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр нь ядуурал, тэгш бус байдал болон уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй шударга бус байдлыг эцэслэх зорилго бүхий НҮБ-ын тэргүүлэх байгууллага юм. Дэлхийн 170 орны түншлэгчид болон мэргэжилтнүүдийн өргөн цар хүрээт хамтын ажиллагааны дүнд эх дэлхий, хүн бүрийн сайн сайхны төлөө хөгжлийн урт хугацааны, цогц шийдлийг бий болгоход улс үндэстнүүдийг дэмжин ажилладаг.

Европын Холбоо бол Европ тивийн 27 тусгаар улсын эдийн засаг, улс төрийн нэгдэл юм. Тус Холбоо нь хүний эрхэм чанар, эрх чөлөө, ардчилал, эрх тэгш байдал, хууль дээдлэх ёс, хүний эрхийг түүний дотор цөөнхийн эрхийг дээдлэх үндсэн үнэт зүйлс дээр тулгуурлан байгуулагджээ. Өнөө цагт Европын Холбоо нь даян дэлхийн хүн бүрд хүртээмжтэй, нийгэм, эдийн засаг, байгаль орчны тогтвортой хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаа явуулж байна.

Ерөнхий мэдэгдэл

978-9919-9177-9-1

Энэхүү тайлан нь төслийн хүрээнд боловсруулагдсан бөгөөд ажлын хэрэгцээнд болон судалгаанд зориулав. Тайлангийн агуулга зөвхөн зохиогчдын үзэл бодлыг илэрхийлж байгаа бөгөөд Европын Холбоо болон НҮБХХ-ийн албан ёсны бодлого, байр суурийг илэрхийлээгүй. Энэхүү тайланд ашигласан мэдээллийн үнэн зөв эсэх, тухайн материалыг ашигласны улмаас гарах үр дагаварт Европын Холбоо, НҮБХХ хариуцлага хүлээхгүй болно. НҮБХХ-ийн зөвшөөрөлгүйгээр энэхүү хэвлэлийг худалдах, дахин хэвлэх, эсвэл ямар нэгэн ашиг олох хэрэгсэл болгохыг хориглоно.

АГУУЛГА

1. Зургийн жагсаалт	4
2. Хүснэгтийн жагсаалт	4
3. СОЁЛЫН САЛБАРЫН ТӨСВИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	5
4. УДИРТГАЛ	7
5. СОЁЛ УРЛАГИЙН САЛБАРЫН ХӨТӨЛБӨР /71700/	8
6. САЛБАРЫН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	9
7. СОЁЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮН, ЗАРДЛЫН ӨГӨӨЖ	14
7.1 ТЕАТР, ЧУУЛГЫН СОЁЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮН, ЗАРДЛЫН ӨГӨӨЖ	15
7.2 МУЗЕЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮН, ЗАРДЛЫН ӨГӨӨЖ	18
7.3 НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮН, ЗАРДЛЫН ӨГӨӨЖ	20
7.4 СОЁЛЫН ТӨВИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮР ДҮН, ЗАРДЛЫН ӨГӨӨЖ	23
7.5 СОЁЛЫН САЛБАРЫН БУСАД ТООН БОЛОН ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТ	24
8. ТӨСВИЙН ХАНГАЛТТАЙ БАЙДАЛ	27
9. ДҮГНЭЛТ	30
10. ЗӨВЛӨМЖ	31

1. ЗУРГИЙН ЖАГСААЛТ

График 1. ДНБ болон улсын төсвийн урсгал зарлагад эзлэх хувь	5
График 2. Зардлын ДНБ-д эзлэх хувь	5
График 3. Гүйцэтгэл, өсөлтийн харьцаа	6
График 4. Нийт зардлын бүтэц	6
График 5. Тоглолт, үзэгчдийн тоо /үзэгчдийн тоо мянгаар/	18
График 6. Музейн үзмэр, үзэгчдийн тоо	20
График 7. Номын сан, фонд	22
График 8. Уншигчдын тоо, суудлын тоо	22
График 9. Соёлын төвийн үзүүлэлт	24
График 10. Салбарын нийт авлага, өр төлбөр /сая.төг/	28

2. ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсвийн үндсэн үзүүлэлт	5
Хүснэгт 2. ТЕЗ-ийн хөтөлбөр	8
Хүснэгт 3. Салбарын төсвийн гүйцэтгэл /хөтөлбөрөөр, мян.төг/	10
Хүснэгт 4. Төсвийн шууд захирагчийн гүйцэтгэл /байгууллагаар мян.төг/	11
Хүснэгт 5. Төсвийн шууд захирагчийн гүйцэтгэл /зориулалтаар сая.төг/	12
Хүснэгт 6. Салбарын төсөв ба гүйцэтгэл /эдийн засгийн ангиллаар сая.төг/	13
Хүснэгт 7. Гүйцэтгэлийн санхүүжилт/орон нутаг дахь байгууллага/	13
Хүснэгт 8. Орон нутгийн төсвийн задаргаа /мян.төг/	14
Хүснэгт 9. Салбарын нэмэлт орлого /мян.төг/	16
Хүснэгт 10. Соёл урлаг хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд	17
Хүснэгт 11. Мэргэжлийн урлагийн байгууллагын зардлын өгөөж	19
Хүснэгт 12. Мэргэжлийн урлагийн үзүүлэлтийн биелэлт	19
Хүснэгт 13. Музейн байгууллагын зардлын өгөөж	20
Хүснэгт 14. Музейн үзүүлэлтийн биелэлт	21
Хүснэгт 15. Номын сангийн зардлын өгөөж	23
Хүснэгт 16. Номын сангийн үзүүлэлтийн биелэлт	24
Хүснэгт 17. Соёлын төвийн үзүүлэлтийн биелэлт	25
Хүснэгт 18. Салбарын бусад үзүүлэлтийн биелэлт	26
Хүснэгт 19. Нийт авлага, өр төлбөр /сая.төг/	28

3. СОЁЛЫН САЛБАРЫН ТӨСВИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


Хүснэгт 1. Төсвийн үндсэн үзүүлэлт

ДНБ-д эзлэх хувь	Улсын нэгдсэн төсвийн зарлагад эзлэх хувь	2023 оны батлагдсан төсөв мян.төг	2023 оны төсвийн гүйцэтгэл мян.төг
0.4%	1.4%	316,989,859.1	311,659,435.0

Салбарын нийт төсвийн ДНБ-д эзлэх хувь 2022 онд 0.3% байсан бол 2023 онд 0.4% болж 1.0 нэгжээр нэмэгдсэн байна.

Харин улсын нэгдсэн төсвийн зарлагад эзлэх хувь 2022 онд 1.0% байсан бол 2023 онд 1.4% болж 0.4 нэгжээр нэмэгдсэн сайн үзүүлэлттэй байна.

График 1. ДНБ болон улсын төсвийн урсгал зарлагад эзлэх хувь



Салбарын төсвийн цэвэр өсөлтийн хувийг авч үзвэл 2021-ээс 2022 оны төсвийн жилийн өсөлт огцом буюу 82.3%-иар нэмэгдэж байсан бол 2022 ба 2023 оны цэвэр өсөлтийн харьцаа 79.1%-тай байна.


Салбарын төсвийн зарлагын гүйцэтгэлийг улсын нэгдсэн төсвийн зарлагатай харьцуулахад 2012 онд 1.5 хувь байсан бол 2023 онд 1.4 хувь болж 0.1 нэгжээр буурсан байна. Соёлын салбарын зарлагын улсын нэгдсэн төсвийн зарлагад эзлэх хувь нь 2012 оны түвшинтэй харьцуулахад бага зэргийн бууралттай тогтмол үзүүлэлттэй байна.

Харин төсвийн зарлагын гүйцэтгэл 2012 оныхтой харьцуулахад 2023 онд 3.3 дахин буюу 234.5 хувиар өссөн байна. Салбарын зарлагын улсын төсвийн гүйцэтгэлд эзлэх хувийн ерөнхий хандлага сөрөг, маш бага бууралттай /бууралтын коэффициент -0.0012/байна.

Монгол Улсын хувьд соёлын салбарт төрөөс зарцуулж байгаа зардлын ДНБ-нд эзлэх хувь хэмжээ хөгжиж буй улс орнуудынхтай ойролцоо боловч хөгжингүй улс орнууд

болон дэлхийн дунджаас ойролцоогоор 2 дахин бага байна. “Соёлын үйлчилгээ”, “нэвтрүүлэх, түгээх үйлчилгээ”-нд улсын төсвөөс зарцуулсан зардлын ДНБ-д эзлэх хувийг бусад оронтой харьцуулж дараах графикт харуулав.


График 2. Зардлын ДНБ-д эзлэх хувь



Эх сурвалж: (UNESCO, 2022)/BOP Consulting (2021)

УИХ-аар салбарын төсөв 316,989.9 сая төгрөг буюу өмнөх оноос 139,616.2 сая төгрөгөөр нэмэгдэж батлагдсан байна. Төсвийн гүйцэтгэл 311,659.4 сая төгрөг буюу 5,330.4 сая төгрөгийн хэмнэлттэй, 98.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

График 3. Гүйцэтгэл, өсөлтийн харьцаа



Салбарын төсөв 2023 онд батлагдахдаа хөрөнгийн зардал 2022 онтой харьцуулахад ихээхэн нэмэгдэж батлагдсан тул нийт зардалд урсгал зардлын эзлэх хувь 64.3%-иас 54.8 болж 9.5 нэгжээр, харин хөрөнгийн зардлын гүйцэтгэлийн хувь 35.7%-иас 45.2% болж 9.5 нэгжээр нэмэгдсэн байна.

График 4. Нийт зардлын бүтэц



4. УДИРТГАЛ

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14.3, 41.2.3, 41.2.7, 41.7 болон 54.5-д заасныг баримтлан Соёлын салбар хариуцсан Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсвийн зарлага болон үр дүнгийн гүйцэтгэлийн тайланг Та бүхэнд хүргэж байна. Соёлын салбар хариуцсан Төсвийн ерөнхийлөн захирагч нь дараах төсвийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Хүснэгт 2. ТЕЗ-ийн хөтөлбөр

71700	Соёл урлаг, спорт, аялал жуулчлал	Төрөл
71702	Соёл урлаг	<ul style="list-style-type: none">Төлөөлөн гүйцэтгэх төрийн чиг үүргийн санхүүжилтийн хөтөлбөрТөсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр
71805	Шинжлэх ухаан, технологи	<ul style="list-style-type: none">Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр

Соёлын салбарын төсвийн зарлага, үр дүнгийн гүйцэтгэлийн жилийн тайланг боловсруулахдаа төсвийн зарлагыг 2023 оны төсвийн жилээр¹, ДНБ-ийг², нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн мэдээг³, салбарын статистик мэдээг⁴ тус бүр Үндэсний статистикийн хорооны 1212.мн сайт-ыг эх үүсвэрээ болгон ашиглав.

¹ СЯ, Төсвийн зарлагын гүйцэтгэлийн мэдээ 2012-2023

² https://1212.mn/mn/statistic/statcate/573052/table-view/DT_NSO_0500_001V1

³ https://1212.mn/mn/statistic/statcate/573058/table-view/DT_NSO_0800_005V1

⁴ <https://1212.mn/mn/statistic/statcate/48171308/table/48171308>

5. СОЁЛ УРЛАГИЙН САЛБАРЫН ХӨТӨЛБӨР /71700/

УИХ-аар салбарын төсөв 316,989.9 сая төгрөг буюу өмнөх оноос 139,616.2 сая төгрөгөөр нэмэгдэж батлагдсан байна. Төсвийн гүйцэтгэл 311,659.4 сая төгрөг буюу 5,330.4 сая төгрөгийн хэмнэлттэй, 98.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Соёл урлаг хөтөлбөр: Тус хөтөлбөрийн төсөв 315,918.2 сая төгрөг буюу өмнөх оноос 139,439.3 сая төгрөгөөр нэмэгдэж батлагдсан байна. Төсвийн гүйцэтгэл 310,656.7 сая төгрөг буюу 5,261.5 сая төгрөгийн хэмнэлттэй, 98.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Шинжлэх ухаан, технологи хөтөлбөр: Тус хөтөлбөрийн төсөв 1,071.7 сая төгрөг буюу өмнөх оноос 176.9 сая төгрөгөөр нэмэгдэж батлагдсан байна. Төсвийн гүйцэтгэл 1,002.8 сая төгрөг буюу 68.9 сая төгрөгийн хэмнэлттэй, 93.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Зардал нэмэгдэж батлагдахад урсгал зардал 57.6 тэрбум, хөрөнгө оруулалтын зардал 82.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Урсгал зардлын өсөлтийн хувьд цалин хөлс, НДШ 12.9 тэрбум, Орон нутгийн соёлын байгууллагуудын гүйцэтгэлээр олгох санхүүжилт 25.9 тэрбумаар нэмэгдсэн байна.

Хөрөнгө оруулалтын зардлын өсөлтийн хувьд барилга, байгууламжийн зардал 62.0 тэрбум, их засвар 2.4 тэрбум, тоног төхөөрөмж худалдаж авах зардал 17.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 3. Салбарын төсвийн гүйцэтгэл /хөтөлбөрөөр, мян.төг/

Салбарын хөтөлбөр	2022		Зөрүү	2023		Зөрүү	Хувь
	Батлагдсан	Гүйцэтгэл		Батлагдсан	Гүйцэтгэл		
0	1	2	3=2-1	4	5	6=5-4	7=5/4
НИЙТ	177,373,671.6	174,028,646.4	-3,345,025.2	316,989,859.1	311,659,435.0	-5,330,424.1	98.3%
Соёл урлаг	176,478,936.3	173,277,603.1	-3,201,333.2	315,918,205.4	310,656,665.4	-5,261,540.0	98.3%
Шинжлэх ухаан, технологи	894,735.3	751,043.3	-143,692.0	1,071,653.7	1,002,769.6	-68,884.1	93.6%

6. САЛБАРЫН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Салбарын батлагдсан төсөв болон гүйцэтгэлийг байгууллагаар авч үзвэл 2023 оны гүйцэтгэлээр хөрөнгө оруулалтын зардал нийт төсвийн 45%, орон нутгийн соёлын байгууллагуудын гүйцэтгэлээр олгох санхүүжилт 31%-ийг эзэлж байна.

Хүснэгт 4. Төсвийн шууд захирагчийн гүйцэтгэл /байгууллагаар мян.төг/

Салбарын хөтөлбөр	2022		Эерүү	2023		Эерүү
	Батлагдсан	Гүйцэтгэл		Батлагдсан	Гүйцэтгэл	
НИЙТ	177,373,671.6	174,028,646.4	3,345,025.2	316,989,859.1	311,659,435.0	5,330,424.1
Үндэсний түүхийн музей	1,229,851.0	1,197,689.8	-32,161.2	1,569,186.5	1,542,763.0	-26,423.5
Байгалийн түүхийн музей	929,753.1	879,616.9	-50,136.2	1,587,891.6	1,514,813.8	-73,077.8
Театрын музей	213,692.9	210,821.2	-2,871.7	358,533.2	357,362.4	-1,170.8
Дүрслэх урлагийн музей	539,116.2	530,578.7	-8,537.5	814,049.7	812,580.1	-1,469.6
Уран зургийн галерей	416,657.6	404,362.6	-12,295.0	737,719.3	702,001.9	-35,717.4
Үндэсний номын сан	1,854,624.6	1,755,585.8	-99,038.8	2,765,038.3	2,681,848.6	-83,189.7
Улсын дуурь бүжгийн эрдмийн театр	4,677,991.3	4,499,828.5	-178,162.8	6,514,705.7	6,413,605.0	-101,100.7
Улсын драмын эрдмийн театр	2,086,567.7	1,892,547.0	-194,020.7	3,089,728.5	3,051,784.5	-37,944.0
Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулга	3,130,852.3	3,120,980.5	-9,871.8	4,586,790.5	4,580,923.3	-5,867.2
Улсын хүүхэддэйн театр	525,781.9	494,771.8	-31,010.1	1,073,569.0	1,045,051.9	-28,517.1
Улсын филармони	2,538,081.6	2,519,637.1	-18,444.5	3,757,885.7	3,706,715.8	-51,169.9
Соёл, урлаг хөгжүүлэх сан	1,511,067.9	1,337,449.1	-173,618.8	800,000.0	642,238.4	-157,761.6
Соёлын өвийн төв	1,374,753.3	1,068,843.4	-305,909.9	1,717,322.1	1,634,196.1	-83,126.0
Богд хааны ордон музей	417,765.4	412,339.5	-5,425.9	658,502.6		#VALUE!
Чойжин ламын сүм музей	362,822.0	349,559.8	-13,262.2	598,964.0	596,714.9	-2,249.1
Хүүхдийн номын ордон	658,434.4	656,505.4	-1,929.0	1,065,780.7	1,030,886.7	-34,894.0
Хархорин музей	508,125.6	496,295.2	-11,830.4	775,050.9	769,957.1	-5,093.8
Хөшөө цайдам музей	232,741.4	226,826.6	-5,914.8	406,727.0	406,504.2	-222.8
Дэлхийн Өв Орхоны соёлын дурсгалт газар	303,047.4	297,678.3	-5,369.1	408,013.5	407,549.6	-463.9
Соёл урлагийн газар	809,190.4	808,836.9	-353.5	1,029,950.4	993,432.7	-36,517.7
Монгол Алтай хадны ЗЦХЗБ	196,295.3	175,523.9	-20,771.4	248,848.7	247,973.7	-875.0
Бурхан халдун уул ТХТГНХЗ	229,609.8	228,906.1	-703.7	368,264.3	356,108.1	-12,156.2
Кино урлагийг дэмжих сан	0.0	0.0	0.0	100,000.0	0.0	-100,000.0
Соёлын яам	4,973,010.9	4,754,102.9	-218,908.0	5,140,866.3	5,098,759.4	-42,106.9
Чингис хаан музей	2,536,122.9	2,511,675.2	-24,447.7	3,396,573.1	3,308,531.8	-88,041.3
Соёлын сайдын шууд	15,928,485.0	15,391,579.2	-536,905.8	23,242,908.6	23,075,347.4	-167,561.2
Соёлын сайдын Хөрөнгө оруулалт /45%/	62,174,373.0	62,174,008.7	-364.3	144,237,331.3	140,726,616.3	3,510,715.0
Хүүхэд залуучуудын театр	285,628.8	110,980.2	-174,648.6	1,077,375.1	785,364.2	-292,010.9
Кино урлагийн зөвлөлийн ажлын алба	326,378.6	265,981.8	-60,396.8	403,452.0	384,124.0	-19,328.0
Аймаг, нийслэлийн соёл, урлагийн газар	4,726,765.0	3,745,438.0	-981,327.0	6,901,388.4	6,654,484.7	-246,903.7
Орон нутгийн соёлын байгууллагуудын гүйцэтгэлээр олгох санхүүжилт. /31%/	60,781,349.0	60,758,653.0	-22,696.0	96,485,788.4	96,483,013.4	-2,775.0
Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн /шинэ/	212,938.7	212,819.0	-119.7	320,873.5	318,533.2	-2,340.3
Чингис хааны өв соёлын хүрээлэн	681,796.6	538,224.3	-143,572.3	750,780.2	684,236.4	-66,543.8

Салбарын батлагдсан төсөв болон гүйцэтгэлийг төсвийн зориулалтаар авч үзвэл 2023 оны гүйцэтгэлээр хөрөнгө оруулалтын зардал нийт төсвийн 45.2%, орон нутгийн соёлын байгууллагуудын гүйцэтгэлээр олгох санхүүжилт 25.6%-ийг эзэлж байна.

Хүснэгт 5. Төсвийн шууд захирагчийн гүйцэтгэл /зориулалтаар сая.төг/

Зориулалт	2022		Зөрүү	2023		Зөрүү
	Батлагдсан	Гүйцэтгэл		Батлагдсан	Гүйцэтгэл	
НИЙТ	177,373.7	174,028.6	-3,345.0	316,989.9	311,659.4	-5,330.5
Үндсэн үйл ажиллагааны зардал	32,235.3	29,780.8	-2,454.5	45,242.9	44,060.6	-1,182.3
Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	197.6	185.0	-12.6	213.5	205.5	-8.0
Мэдээлэл, сурталчилгааны зардал	973.4	973.1	-0.3	3.7	3.5	-0.2
Уран бүтээл хийлгэх	491.9	490.8	-1.1	359.3	339.1	-20.3
Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	81.9	81.8	-0.1	57.3	51.2	-6.2
Харуул, хамгаалалтын зардал	291.8	290.3	-1.5	222.2	219.6	-2.6
Байр ашиглалтын үйлчилгээ	278.5	273.8	-4.7	242.7	242.5	-0.2
Тээврийн үйлчилгээ	0.0	0.0	0.0	172.2	172.2	0.0
Гадаадын болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	0.7	0.0	-0.7	0.0	0.0	0.0
Ахмад дайчин, алдар цолтой ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламж	921.0	918.8	-2.2	991.0	990.4	-0.6
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	2,591.7	2,511.2	-80.5	12,870.4	12,746.5	-123.9
Бусад	62,174.4	62,174.0	-0.4	144,237.3	140,726.6	-3,510.7
Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт	0.0	0.0	0.0	8,000.0	7,951.6	-48.4
Соёл урлаг хөгжүүлэх	5,014.6	4,611.9	-402.8	12,294.7	12,109.5	-185.2
Музейн үзмэр худалдан авах	84.0	84.0	0.0	57.7	57.7	0.0
Түүхийн хурд баримтат кино бүтээх	92.4	92.4	0.0	63.4	63.4	0.0
Түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах	1,154.5	1,143.2	-11.3	486.3	460.0	-26.3
Музей, түүх, соёлын өвийн сэргээн засварлалт	0.9	0.9	0.0	0.6	0.6	0.0
Хөгжмийн шилдэг бүтээлийг улсын санд худалдаж авах	42.0	42.0	0.0	28.8	28.8	0.0
Дүрслэх урлагийн шилдэг бүтээлийг улсын санд худалдаж авах	42.0	42.0	0.0	28.8	28.8	0.0
Соёл урлагийн олон улсын тэмцээнд тэргүүн байр эзэлсэн уран бүтээлчдийг шагнах	154.0	154.0	0.0	160.0	159.9	-0.1
Оны шилдэг уран бүтээлч найруулагч жүжигчин зураач бүжигчдийг шагнах	45.0	44.9	-0.1	44.1	43.9	-0.2
Гадаад дотоодод зохиогдох соёл урлагийн арга хэмжээ	1,669.3	1,600.4	-68.9	2,766.5	2,754.0	-12.5
Кино урлагийг дэмжих	0.0	0.0	0.0	100.0	0.0	-100.0
Соёлын бүтээлч үйлдвэрлэл	1,720.0	1,553.4	-166.6	2,576.6	2,573.6	-2.9
Цахим соёл хөтөлбөр	1,055.0	1,035.9	-19.1	500.0	442.1	-57.9
Музейн үзмэртэй шууд харьцах албан тушаалтанд төрөөс үзүүлэх дэмжлэг	530.1	464.2	-65.9	10.5	10.5	0.0
Бүх нийтийн соёлын боловсрол	341.7	327.7	-13.9	310.0	268.8	-41.2
Соёлын байгууллагад гүйцэтгэлээр олгох санхүүжилт /театр чуулга/	58,654.6	58,644.8	-9.7	79,828.2	79,827.5	-0.6
Нүүдлийн өв, соёлыг дэмжих хөтөлбөр	168.1	168.0	-0.1	0.0	0.0	0.0
Монголын түүх, соёл, үндэсний урлагийг гадаад, дотоодод түгээн сурталчлах хөтөлбөр	336.2	308.3	-27.8	0.0	0.0	0.0
Номын баяр арга хэмжээ	840.4	840.0	-0.4	220.0	220.0	0.0
Улсын их баяр наадам	0.0	0.0	0.0	4,901.0	4,901.0	0.0
Түүхэн ой	5,190.6	5,190.6	0.0	0.0	0.0	0.0

Хүснэгт 6. Салбарын төсөв ба гүйцэтгэл /эдийн засгийн ангиллаар сая.төг/

Код	Зардлын ЭЗ-ийн ангилал	2021		2022		2023	
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл
	НИЙТ	138,089.0	131,555.2	177,373.7	174,028.6	316,989.9	311,659.4
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	18,681.9	17,326.9	24,966.7	23,116.1	36,440.0	35,675.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,600.9	2,266.8	3,212.9	2,903.7	4,638.5	4,437.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,197.5	1,118.1	1,504.1	1,391.4	1,994.4	1,875.7
2104	Хангамж, бараа материалын зардал	678.1	666.5	638.2	586.1	541.8	520.0
2105	Нормативт зардал	52.5	52.4	39.9	34.0	18.2	15.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	202.8	189.5	474.6	458.6	1,641.7	1,621.7
2107	Томилолт, зочны зардал	18.5	14.7	64.9	45.3	87.0	78.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,896.2	16,481.4	18,091.3	17,513.4	21,464.6	21,074.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,177.6	2,117.3	3,309.7	3,068.0	6,889.3	6,723.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,744.1	1,596.4	62,897.0	62,738.0	99,037.0	98,910.6
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.8	0.0	58,655.2	58,644.8	84,628.2	84,627.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,743.2	1,596.4	4,241.8	4,093.1	14,408.9	14,283.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	92,839.1	89,725.3	62,174.4	62,174.0	144,237.3	140,726.6
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	138,089.0	131,555.2	177,373.7	174,028.6	316,989.9	311,659.4
31	Улсын төсвөөс санхүүжих	138,089.0	131,554.1	177,373.7	174,025.8	316,989.9	311,657.3

Салбарын орон нутаг дахь байгууллагын улсын төсвийн санхүүжилтийн гүйцэтгэл.

Улсын төсөвт орон нутаг дахь соёлын байгууллагын гүйцэтгэлээр олгох санхүүжилт 2023 онд 96,485.8 сая төгрөг батлагдсанаас 96,483.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэйгээр буюу 2.8 сая төгрөгийн хэмнэлттэйгээр улсын төсвөөс санхүүжүүлсэн байна. Нийт гүйцэтгэлийн хувьд авч үзвэл 2022 оны төсөвтэй харьцуулахад 36.3 тэрбум төгрөгөөр илүү байгаа бөгөөд гол нөлөө нь цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 7. Гүйцэтгэлийн санхүүжилт/орон нутаг дахь байгууллага/

Орон нутаг дахь байгууллагын улсын төсвийн санхүүжилт	2022		Зөрүү	2023		Зөрүү
	Батлагдсан	Гүйцэтгэл		Батлагдсан	Гүйцэтгэл	
Орон нутгийн соёлын байгууллагуудын гүйцэтгэлээр олгох санхүүжилт. Үүнээс:	60,781,349.0	60,758,653.0	-22,696.0	96,485,788.4	96,483,013.4	-2,775.0
Музейн үйлчилгээ		5,026,183.6			7,930,321.8	
Номын сангийн үйлчилгээ		5,111,939.2			7,798,974.2	
Соёлын төвийн үйлчилгээ		30,473,549.3			46,878,357.6	
Театр чуулгын үйлчилгээ		20,146,980.9			33,875,359.8	

Орон нутгийн байгууллагын нийт гүйцэтгэлийг авч үзвэл 2023 онд нийт 119.9 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд энэ нь 2022 онтой харьцуулбал 34.9 тэрбум төгрөгөөр илүү байна. Гүйцэтгэлийг байгууллагын төрөл тус бүрээр авч үзвэл. Үүнд:

Музейн үйлчилгээний хувьд 9.6 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа ба өмнөх оноос 2.8 тэрбум төгрөг илүү зарцуулжээ. Төсвийн тухай хуулийн дагуу байр ашиглалттай холбоотой зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлдэг ба тус үйлчилгээний хувьд 686.5 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн ба энэ нь өмнөх оноос 237.3 сая төгрөгөөр илүү байна.

Номын сангийн үйлчилгээний хувьд 8.6 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа ба өмнөх оноос 2.4 тэрбум төгрөг илүү зарцуулжээ. Төсвийн тухай хуулийн дагуу байр ашиглалттай холбоотой зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлдэг ба тус үйлчилгээний хувьд 871.4 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн ба энэ нь өмнөх оноос 123.9 сая төгрөгөөр илүү байна.

Соёлын төвийн үйлчилгээний хувьд 62.7 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа ба өмнөх оноос 17.4 тэрбум төгрөг илүү зарцуулжээ. Төсвийн тухай хуулийн дагуу байр ашиглалттай холбоотой зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлдэг ба тус үйлчилгээний хувьд 16.4 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдсэн ба энэ нь өмнөх оноос 2.8 тэрбум төгрөгөөр илүү байна.

Театр чуулгын үйлчилгээний хувьд 39.0 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа ба өмнөх оноос 12.2 тэрбум төгрөг илүү зарцуулжээ. Төсвийн тухай хуулийн дагуу байр ашиглалттай холбоотой зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлдэг ба тус үйлчилгээний хувьд 4,783.9 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн ба энэ нь өмнөх оноос 797.1 сая төгрөгөөр илүү байна.

Хүснэгт 8. Орон нутгийн төсвийн задаргаа /мян.төг/

Орон нутаг, байгууллагын төрөл, эдийн засгийн ангилал	2022 оны гүйцэтгэл	2023 оны гүйцэтгэл	Зөрүү
Соёл урлаг	85,083,878.0	119,940,728.0	34,856,850.0
Музейн үйлчилгээ	6,833,551.5	9,647,827.3	2,814,275.8
001637_2101 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,798,926.4	5,539,823.5	1,740,897.1
001709_2102 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	468,456.8	686,517.4	218,060.6
001785_2103 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	901,685.7	1,138,940.4	237,254.7
001858_2104 Хангамж, бараа материалын зардал	158,398.0	177,327.5	18,929.5
001955_2105 Нормативт зардал	9,448.1	6,481.2	(2,967.0)
002000_2106 Эд хогшил, урсгал засварын зардал	202,781.5	262,716.0	59,934.5
002055_2107 Томиллолт, зочны зардал	27,467.1	47,921.0	20,453.9
002099_2108 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	417,447.0	472,213.2	54,766.2
002251_2109 Бараа үйлчилгээний бусад зардал	159,395.1	295,873.4	136,478.3
002433_2132 Бусад урсгал шилжүүлэг	385,952.6	1,020,013.7	634,061.1
002534_2133 Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	59,965.3	-	(59,965.3)
002601_2134 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	243,627.9	-	(243,627.9)
Номын сангийн үйлчилгээ	6,196,054.5	8,601,836.4	2,405,781.9
001637_2101 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,704,864.6	5,346,942.7	1,642,078.1
001709_2102 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	468,953.6	671,459.7	202,506.1
001785_2103 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	747,410.5	871,361.2	123,950.7
001858_2104 Хангамж, бараа материалын зардал	151,457.1	133,948.7	(17,508.4)
001955_2105 Нормативт зардал	5,028.7	3,039.4	(1,989.3)
002000_2106 Эд хогшил, урсгал засварын зардал	139,380.1	167,805.2	28,425.1
002055_2107 Томиллолт, зочны зардал	16,424.3	28,410.7	11,986.4
002099_2108 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	442,127.6	330,641.0	(111,486.6)
002251_2109 Бараа үйлчилгээний бусад зардал	272,059.3	172,898.5	(99,160.8)
002433_2132 Бусад урсгал шилжүүлэг	215,351.1	875,329.1	659,978.1
002534_2133 Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,267.6	-	(2,267.6)
002601_2134 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, Санхүүжилт	30,730.1	0.0	(30,730.1)

Орон нутаг, байгууллагын төрөл, эдийн засгийн ангилал	2022 оны гүйцэтгэл	2023 оны гүйцэтгэл	Зөрүү
Соёлын төвийн үйлчилгээ	45,232,372.7	62,657,838.3	17,425,465.7
001637_2101 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	21,891,888.0	31,239,867.0	9,347,979.0
001709_2102 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,775,130.3	3,970,106.9	1,194,976.6
001785_2103 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,544,572.4	16,390,630.6	2,846,058.3
001858_2104 Хангамж, бараа материалын зардал	844,523.2	880,419.2	35,896.0
001955_2105 Нормативт зардал	48,439.0	24,986.9	(23,452.1)
002000_2106 Эд хогшил, урсгал засварын зардал	1,059,592.9	1,501,350.5	441,757.6
002055_2107 Томилолт, зочны зардал	112,396.0	159,757.6	47,361.6
002099_2108 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,960,814.2	1,869,975.9	(90,838.3)
002251_2109 Бараа үйлчилгээний бусад зардал	940,485.8	795,885.4	(144,600.4)
002433_2132 Бусад урсгал шилжүүлэг	1,164,043.8	5,823,733.7	4,659,689.9
002534_2133 Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,990.4	-	(25,990.4)
002601_2134 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	864,496.8	1,124.7	(863,372.1)
Театр чуулгын үйлчилгээ	26,821,899.3	39,033,226.0	12,211,326.6
001637_2101 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	15,709,868.8	22,477,145.4	6,767,276.6
001709_2102 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,960,491.4	2,809,372.4	848,881.0
001785_2103 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,986,912.1	4,783,962.2	797,050.2
001858_2104 Хангамж, бараа материалын зардал	363,871.1	360,601.2	(3,270.0)
001955_2105 Нормативт зардал	26,223.2	11,989.4	(14,233.8)
002000_2106 Эд хогшил, урсгал засварын зардал	515,099.3	967,574.0	452,474.6
002055_2107 Томилолт, зочны зардал	121,603.3	166,146.9	44,543.6
002099_2108 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,158,893.9	1,834,719.5	(324,174.4)
002251_2109 Бараа үйлчилгээний бусад зардал	778,892.1	627,905.9	(150,986.2)
002433_2132 Бусад урсгал шилжүүлэг	661,664.5	4,993,809.1	4,332,144.6
002534_2133 Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	223.3	-	(223.3)
002601_2134 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	538,156.2	-	(538,156.2)

Салбарын 2023 онд олсон нэмэлт орлого 17.1 тэрбум төгрөг ба энэ нь өмнөх оны гүйцэтгэлээс 4.8 тэрбум төгрөгөөр илүү байна. Нийт орлогоос соёл урлагийн хөтөлбөрийн орлого 17.0 тэрбум, шинжлэх ухааны хөтөлбөрийн орлого 84.5 тэрбум төгрөг тус тус байна.

Хүснэгт 7. Гүйцэтгэлийн санхүүжилт/орон нутаг дахь байгууллага/

Хөтөлбөр, нэмэлт орлого	2022 оны гүйцэтгэл	2023 оны гүйцэтгэл	Зөрүү
Соёл урлаг	12,256,714.5	17,016,476.7	4,759,762.2
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	777,491.1	578,128.7	(199,362.5)
Засаг дарга, ЗГ-ын нөөц хөрөнгөөс хуваарилсан орлого	4,864,202.6	3,710,606.4	(1,153,596.2)
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,615,020.8	12,727,741.6	6,112,720.8
Шинжлэх ухаан, технологи	47,157.2	84,516.8	37,359.7
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	47,157.2	84,516.8	37,359.7
НИЙТ ОРЛОГО	12,303,871.7	17,100,993.6	4,797,121.9

7. СОЁЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮН, ЗАРДЛЫН ӨГӨӨЖ

Монгол Улсын тухайн жилийн төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн тухайн онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн чанарын болон тоон шалгуур үзүүлэлтийг баталдаг. Төсвийн ерөнхийлөн захирагч (сайд) нар төсвийн жил дууссаны дараа төсвийн гүйцэтгэлийн тайланг гаргаж, СЯ-нд ирүүлэх үүргийг Төсвийн тухай хуулиар хүлээдэг. Уг тайланд хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлтийг багтаасан байх ёстой. СЯ-аас Монгол Улсын жилийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэж дараа оны 5 дугаар сарын 10-ны дотор төрийн аудитын төв байгууллагад хүргүүлэх ба аудитын байгууллагын дүгнэлт гарсны дараа УИХ-аар хэлэлцүүлж, гүйцэтгэлийг батлуулдаг.

Монгол Улсын 2021, 2022, 2023 оны төсвийн тухай хуулиудаар баталсан соёл урлаг хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг дараах хүснэгтэд харьцуулан харуулав.

Хүснэгт 10. Соёл урлаг хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд

	Хөтөлбөрийн үр дүнгийн чанарын ба тоон шалгуур үзүүлэлтүүд	2021 оны зорилтот түвшин	2022 оны зорилтот түвшин	2023 оны зорилтот түвшин	2023 оны гүйцэтгэл
1	Соёл урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчийн тоо /хүн амд эзлэх хувиар/	75.0	75.0	78.0	Биелсэн
2	Нийтийн номын сангийн байнгын уншигч /хүн амд эзлэх хувиар/	15.0	15.0	15.0	Биелээгүй
3	Музейн үзэгчийн тоо /хүн амд эзлэх хувиар/	21.0	21.0	21.0	Биелсэн
4	Жилийн эцэст хүрсэн байх музейн үзмэрийн тоо /мянгаар/	245.0	245.0	245.0	Биелсэн
5	10000 хүнд ногдох номын тоо /мянган ширхэг/	28.0	28.0	28.0	Биелээгүй
6	10000 хүнд ногдох соёлын төвийн суудлын тоо	300	300	300	Биелээгүй
7	Улсын хэмжээнд хэрэгжүүлсэн үндэсний хөтөлбөрийн тоо	3-аас доошгүй	3-аас доошгүй	21	Биелсэн
8	Мэргэжлийн урлагийн байгууллагын үзэгчдийн тоо /давхардсан тоогоор, сая хүн/	3.6	3.6	3.6	Биелээгүй

Монгол Улсын 2021, 2022, 2023 оны төсвийн тухай хуулийн нэгдүгээр хавсралтаар баталсан соёл урлаг хөтөлбөрийн 8 шалгуур үзүүлэлтээс 5 шалгуур үзүүлэлтийг 2013 оноос хойш өөрчлөөгүй байна. Түүнчлэн сүүлийн 3 жилийн хугацаанд дээрх 8 үзүүлэлт өөрчлөгдөөгүй ба зорилтот түвшнийг ямар нэг ахиц дэвшил, өөрчлөлтгүй жил бүр ижил хэмжээгээр авч байжээ. Зөвхөн 2023 онд соёл урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчийн тоог 2022 оныхоос 3 пунктээр нэмэгдүүлж 78 хувьд хүргэх, хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрийн тоог 21 болгоно гэж 2022 оныхоос 7 дахин өндөр зорилт тус тус тавьж өөрчилсөн байна. Харин Соёлын сайдын төсөв 2020 онд 180.8 тэрбум төгрөгөөр батлагдсан байсан бол 2021 онд 138.1 тэрбум болж 24%-аар буурсан, 2022 онд 177.4 тэрбум төгрөгөөр батлагдаж өмнөх оноос 28%-аар, тус тус нэмэгдсэн байна. Ийнхүү соёлын салбарын төсвийн хэмжээ өөрчлөгдөж байсан боловч төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн зорилтот түвшнийг өөрчлөөгүй байна.

Хөтөлбөрийн хүрэх үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийг Төсвийн тухай хуулиар баталдаг боловч хөтөлбөрийн үр дүнгийн томъёолол хуульд тусгагдахгүй байна. Соёл урлаг хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд зөвхөн тоон шалгуур үзүүлэлтүүд бөгөөд төсвийн хөрөнгөөр хөтөлбөр хэрэгжүүлснээр хүрэх үр дүнг бус зөвхөн хийх ажил, үйлчилгээний гарцын үзүүлэлтийг хэмжих шалгуур төдий байна. ҮСХ-ны вэбсайтад байршуулсан соёлын салбарын статистик үзүүлэлт хязгаарлагдмал агуулгатай, соёлын үйлчилгээний үр дүн, иргэдийн соёлын боловсролын нөхцөл, байдал эсхүл үйлчилгээний хүртээмж, агуулгын талаарх түүвэр судалгаа, дүн шинжилгээний ажил бараг хийгдээгүй учраас соёлын үйлчилгээний хүн амын хөгжилд үзүүлж байгаа үр нөлөө, эдийн засгийн өсөлт, хөгжилд үзүүлэх өгөөжийн талаар дүгнэлт хийх боломжгүй байна. Харин Соёлын яамнаас судалгааны байгууллагатай хамтран 2021 онд Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн суурь судалгааг хийсэн нь соёлын бүтээлч үйлдвэрлэлийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлсон чухал судалгаа болсон байна. Цаашид соёлын байгууллагуудаас авдаг захиргааны тоон мэдээллийг сайжруулах, албан ёсны статистик үзүүлэлтүүдийг шинэчлэх, соёлын бүтээлч үйлдвэрлэл, соёлын салбарын хувийн хэвшилд ажиллагчдын тооны статистик мэдээлэл зэргийг тооцдог болох шаардлагатай байна.

ЮНЕСКО-оос Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан соёлын салбарын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх тоон болон чанарын шалгуур үзүүлэлтийг 2019 онд боловсруулж, улс орнуудыг ашиглахыг зөвлөмж болгосон. Энэхүү шалгуур үзүүлэлтийн багцад соёлын салбарын үр дүнг үндсэн 4 бүлэгт хувааж, үр дүнг үнэлэх тоон болон чанарын 22 шалгуур үзүүлэлтийн тодорхойлолт, зорилго, тооцох аргачлалыг гаргасан байна. (UNESCO, 2019) Эдгээр шалгуур үзүүлэлтийг тооцох аргачлалыг монгол хэлээр орчуулан манай улсад хэрэглэж болох эсэх тухай зөвлөмжийн хамт энэхүү тайлангийн сүүлийн бүлэгт оруулсан болно. Манай улсын хувьд Дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилгын 244 шалгуур үзүүлэлтийн 20 шалгуур үзүүлэлтийг буюу дөнгөж 8% нь манай хөгжлийн урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд ашигласан нь хангалтгүй байгаа учраас цаашид өөрийн орны бодлогын баримт бичигт ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийг тусгахыг эрмэлзэх шаардлагатай байна.

Салбарын хэмжээнд Хөтөлбөрийн үр дүнгийн чанарын ба тоон шалгуур 8 үзүүлэлт батлагдсан бөгөөд үүнээс 4 үзүүлэлт биелж, 4 үзүүлэлт биелээгүй байна.

7.1 ТЕАТР, ЧУУЛГЫН СОЁЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮН, ЗАРДЛЫН ӨГӨӨЖ

Төрийн болон орон нутгийн өмчийн соёл, урлагийн байгууллагууд 2020-2021 онд цар тахлын нөхцөл байдал, үйл ажиллагааны хязгаарлалтаас шалтгаалан үйлчилгээ, үйлчлүүлэгчдийн тоо 2019 оны үеэс жилд 30-50 хувиар буурсан. 2022 онд танхимын үйл ажиллагааг сэргээж цахимаар үзүүлэх үйлчилгээг үргэлжлэн хэрэгжүүлснээр үзвэр, үйлчилгээ, үйлчлүүлэгчдийн тоо III дугаар улирлын гүйцэтгэлээр 2021 оны мөн үеэс 30 хувиар өсөж, 2 сая 877 мянга болсон.


Харин 2023 онд үзэгчдийн тоо 2,559 болж өмнөх оны түвшнээс 280-аар буурсан бол үйлчлүүлэгчдийн тоо 1 сая 502 мянга болж 2022 оноос 245.4 мянган хүнээр нэмэгдсэн байна.

Энэ нь давхардсан тоогоор Монгол Улсын жилийн дундаж хүн ам /3 сая 481 мянган/-ын 42%-тай тэнцэх буюу давхардсан тоогоор 2 хүний нэг нь соёлын үйлчилгээ авч байна гэсэн үзүүлэлт юм.

Театр, чуулгын соёлын байгууллагуудад Дуурь бүжгийн эрдмийн театр, Үндэсний урлагийн их театр, Улсын филармони, Улсын драмын эрдмийн театр, Улсын хүүхэлдэйн театр, Хүүхэд залуучуудын гэсэн төрийн өмчит 6 байгууллага болон орон нутгийн өмчит 24 Хөгжимт жүжгийн театр, чуулга нийт 30 байгууллага улсын төсвөөс санхүүжилт авч байна.

Мэргэжлийн урлагийн байгууллага 2012-2019 онд жилд 4000 гаруй тоглолт тогтмол хийж байсан бол 2020-2021 онд цар тахлын нөлөөгөөс үүдэн тоглолтын тоо огцом буурч дунджаар 1,300, харин 2022-2023 онд нэмэгдэж дунджаар 2,700 болсон байна. Үзэгчдийн тоо нь тоглолтын тооноос төдийлөн хамаарахгүйгээр хэлбэлзэл ихтэй байжээ. Тухайлбал, 2014 онд 4,358 тоглолтыг давхардсан тоогоор 1,603.3 мянган хүн үзсэн бол 2015 онд 4,442 тоглолт хийхэд 4,642.7 мянган үзэгчтэй байжээ.

График 5. Тоглолт, үзэгчдийн тоо /үзэгчдийн тоо мянгаар/



Мэргэжлийн урлагийн байгууллагуудын үйл ажиллагааны орлого Ковидын дараа 2022 онд огцом нэмэгдэж, 3.0 тэрбум төгрөгт хүрсэн бол 2023 онд 5.1 тэрбум болж огцом нэмэгдсэн байна.

2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаас харахад орон нутгийн өмчит 24 Хөгжимт жүжгийн театр, чуулгын үйл ажиллагааны өөрийн орлого 1.5 тэрбум төгрөг бол мэргэжлийн урлагийн төрийн өмчит 6 байгууллагын орлого 3.7 тэрбум төгрөг байна.

Харин театр, чуулгууд нь 2022 онд 100 төгрөг зарцуулаад 9 төгрөгийн орлого олдог байсан бол 2023 онд энэ үзүүлэлт 7 болж буурсан байна. Энэхүү үзүүлэлт нь 2023 онд орон нутгийн театр чуулгын хувьд 4, төвийн урлагийн байгууллагын хувьд 11 төгрөг байна.

Орон нутгийн өмчит 24 Хөгжимт жүжгийн театрын жилийн орлого 1.5 тэрбум төгрөг байгааг 24 театрт хуваахад дунджаар 62.5 сая төгрөг болж байгаа нь хангалтгүй байна. Эдгээр 24 театр нийтдээ наад зах нь 500.0 мянган хүнд үйлчилсэн гэж үзэхэд 1 үзэгчээс 125 төгрөгийн орлого олсон гэж үзэхээр байна.

Хүснэгт 11. Мэргэжлийн урлагийн байгууллагын зардлын өгөөж

Үзүүлэлт	Үзэгчид (мянган хүн)	Нийт урсгал зардал (сая төг.)	Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого (сая төг.)	1 үзэгчид ногдох үйл ажиллагааны зардал (төгрөг)	100 төгрөгийн зардалд ногдох өөрийн орлого (төгрөг)
2022 он. Үүнээс:	1256.9	32,785.7	3,023.1	26,085	9
2023 он. Үүнээс:	1502.3	74,421.7	5,146.0	49,539	7
Орон нутгийн театр чуулга		41,775.9	1,487.1		4
Төвийн урлагийн байгууллага		32,645.8	3,658.9		11

Эх сурвалж: Соёлын яам, Төсвийн үр дүнгийн тайлан 2022, 2023

Мэргэжлийн урлагийн байгууллагатай холбоотой үзүүлэлтийн биелэлт:

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн нэгдүгээр хавсралтаар мэргэжлийн урлагийн байгууллагатай холбоотой дараах үзүүлэлт батлагдсан байна.

Чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн гүйцэтгэлийн хувь 41.7 хувьтай буюу зорилтот түвшин биелээгүй байна.

Хүснэгт 12. Мэргэжлийн урлагийн үзүүлэлтийн биелэлт

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт	Суурь он	Суурь түвшин	2023 оны зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэлийн хувь
33.1.8 Мэргэжлийн урлагийн байгууллагын үзэгчдийн давхардсан тоо /сая хүн/	2021	1.3	3.6	1.5	41.7%

33.1.8. Мэргэжлийн урлагийн байгууллагын үзэгчдийн давхардсан тоо /сая хүн/⁵

Тайлбар: Урлагийн байгууллагын тоглолт үзэгчийн тоо 2022 онд 1,256,876 байсан бол 2023 онд 1,502,315 болж 19.5%-иар нэмэгдсэн. 2023 онд Дундговь аймагт 3000 уртын дуу, морин хуурчдын эвент арга хэмжээ болсноор Төв халхын дуулалт жүжгийн театрын нийт үйлчлүүлэгчийн тоо 183070 болж өмнөх оноос 26 хувиар өссөн. Орхон аймгийн хүүхэд залуучуудын театр 2023 онд Дундговь аймагт болсон “Уяхан замбуу тивийн наран” эвент арга хэмжээнд оролцсон тул үйлчлүүлэгчийн тоо оноос 70078 болж өмнөх оноос 3 дахин өссөн үзүүлэлттэй байна. Завхан аймгийн Хөгжимт жүжгийн театр нь “Асрын өндөр” түүхэн аялгуут жүжгийг 2023 оны 05 дугаар сард Улаанбаатар, Дархан хотноо тоглосон учраас тус хотуудад урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдсэн.

Тооцох аргачлал: /Урлагийн байгууллагын үзэгчдийн тоог 1,000,000-д харьцуулан бодож гаргасан. Урлагийн байгууллагын үзэгчдийн тоо-1,502,315/


⁵ Соёлын яам. 2024 он

7.2 МУЗЕЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮН, ЗАРДЛЫН ӨГӨӨЖ

Улаанбаатар хот, Архангай, Өвөрхангай аймагт төрийн өмчийн нийт 14 музей байдаг бол аймаг болгонд болон нийслэлд орон нутгийн өмчит нийт 23 музей байна. Түүнчлэн төрийн өмчит Уран зургийн галерей нийслэл хотод байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн музейн үзмэрийн тоо 2018 онд бусад оныхоос өндөр буюу 289,589 хүрсэн ч 2019 онд 16%-аар буурч, 2020-2021 онд үзмэрийн тоо мөн буурсан, харин 2022-2023 онд 249,264-249,727 үзмэрийн тоотой байна. Музейн үзэгчдийн тоо ба үзмэрийн тооны хооронд шууд хамаарал байхгүй байна.

График 6. Музейн үзмэр, үзэгчдийн тоо



Музейн үзэгчдийн тоо жил бүр буурах хандлагатай бол урсгал зардал нь жил бүр нэмэгдэх хандлагатай байна. Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авдаг нийт музейн үзэгчдийн тоо, урсгал зардал, үндсэн үйл ажиллагаанаас олсон өөрийн орлого зэрэг үзүүлэлтийг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 13. Музейн байгууллагын зардлын өгөөж

Үзүүлэлт	Үзэгчид (мянган хүн)	Нийт урсгал зардал (сая төг.)	Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого (сая төг.)	1 үзэгчид ногдох үйл ажиллагааны зардал (төгрөг)	100 төгрөгийн зардалд ногдох өөрийн орлого (төгрөг)
2022 он	972.8	14,016.9	2,367.5	14,409	17
2023 он. Үүнээс:	1158.2	30,123.9	6,727.7	26,009	22
Орон нутгийн өмчит музей		10,807.5	814.7		8
Төрийн өмчит музей		19,316.4	5,913.0		31

Орлого олох боломжтой дараагийн соёлын үйлчилгээ бол музейн үйлчилгээ юм. 2013-2018 онд музейн салбар жилд 532.8-878.5 сая төгрөгийн орлого олсон бол Ковидын дараа 2022 онд 2.3 тэрбум төгрөгийн, 2023 онд энэ үзүүлэлт 3 дахин их буюу 6.7 тэрбум төгрөгийн орлого олжээ. Музейн 1 үзэгчид ногдох үйл ажиллагааны зардал 2022 онд дунджаар 14,409 төгрөг байсан бол 2023 онд 26,009 болж нэмэгдсэн байна. Энэ үзүүлэлт театр, чуулгын үйлчилгээний хувьд 49,539 төгрөг гарч байснаас бараг 2 дахин бага байна. 2022 онд музейн үйлчилгээнд зарцуулсан 100 төгрөг тутамд 17 төгрөгийн орлого олсон бол энэ үзүүлэлт 2023 нэмэгдэж 22 төгрөг болсон сайн үзүүлэлттэй байна. Энэхүү үзүүлэлт нь 2023 онд орон нутгийн музейн хувьд 8, төрийн өмчит музейн хувьд 4 дахин их буюу 31 төгрөг байна.

Цаашид ялангуяа дэвшилтэт техник технологийн тусламжтайгаар үйлчилгээний онлайн хувилбарыг нэвтрүүлж, музейгээр үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлэх боломжийг эрэлхийлж, төсвийн хөрөнгийн үр ашиг, үр нөлөөг сайжруулах нь зүйтэй юм.

Музейн байгууллагатай холбоотой үзүүлэлтийн биелэлт:

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн нэгдүгээр хавсралтаар музейн үйл ажиллагаатай холбоотой дараах 2 үзүүлэлт батлагдсан байна.

1. “33.1.3- Музейн үзэгчдийн хүн амд эзлэх хувь” үзүүлэлтийн хувьд зорилтот түвшнээс 18 нэгжээр илүү буюу 39%-д хүрч гүйцэтгэл 185.7%-тай байна.
2. “33.1.4- Жилийн эцэст хүрсэн байх музейн үзмэрийн тоо /мянгаар/” үзүүлэлтийн хувьд зорилтот түвшнээс 4.7-оор илүү буюу 249,727-д хүрч гүйцэтгэл 101.9%-тай байна.

Музейн үйл ажиллагаатай холбоотой тоон болон чанарын 2 үзүүлэлт биелсэн байна.

Хүснэгт 14. Музейн үзүүлэлтийн биелэлт

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт		Суурь он	Суурь түвшин	2023 оны зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэлийн хувь	
33.1	Соёл урлаг						
	33.1.3	Музейн үзэгчдийн хүн амд эзлэх хувь	2021	9	21	39	185.7%
	33.1.4	Жилийн эцэст хүрсэн байх музейн үзмэрийн тоо /мянгаар/	2021	243.1	245	249.7	101.9%

33.1.3. Музейн үзэгчдийн хүн амд эзлэх хувь⁶

Тайлбар: Үндэсний статистикийн хорооны мэдээгээр Монгол Улсын 6-аас дээш насны хүн амын тоо 2,961,726.

Музейн үзэгчийн тоо 1,158,176 байгаа нь 6-аас дээш насны хүн амын 39.1 хувийг эзэлж байна. Улсын хэмжээнд музейн нийт үйлчлүүлэгчдийн тоо 2023 онд 1,158,176 болж 185,408-аар өссөн. “Музейн нээлттэй өдрүүд” арга хэмжээг 2022 оноос эхлэн улсын

⁶ Соёлын яам

хэмжээнд зохион байгуулж тогтмолжсон, тус арга хэмжээг жил бүрийн 3 дугаар сарын эхний 7 хоногт зохион байгуулах Монгол Улсын Засгийн газрын 96 дугаар тогтоол гарсан. Монгол улсад орчин цагийн музейн байгууллага байгуулагдсаны 100 жилийн ойг угтан Соёлын яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжийн дагуу “Музейн нээлттэй өдрүүд” арга хэмжээний хүрээнд музейн үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдүүлсэн тусгай үзэсгэлэн, боловсролын хөтөлбөр, лекц, уулзалт зэрэг нийгэмд чиглэсэн олон үйл ажиллагааг зохион байгуулсан учраас үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдсэн.

Тооцох аргачлал: /Музейн үйлчлүүлэгчдийн тоог 6-аас дээш насны хүн амын тоонд харьцуулан 100-аар үржүүлж бодож гаргасан. Музейн үйлчлүүлэгчдийн тоо-1,158,176/

33.1.4. Жилийн эцэст хүрсэн байх музейн үзмэрийн тоо /мянгаар/

Тайлбар: 2022 онд музейн үзмэр 249,264 байсан бол 2023 оны статистик мэдээгээр 249,727 болсон байна. Өмнөх оноос 463 үзмэрээр нэмэгдсэн байна. Музей нь соёлын үнэт зүйлсийг хайгуул, малтлага, судалгааны ажлын үр дүнд, олж авах, өв, бэлэглэлийн журмаар болон худалдан авах, эрх бүхий байгууллагын шийдвэрээр шилжүүлж авах, өөрийн хөрөнгөөр бүтээлгэх, хандив, тусламжаар авах гэх мэт хэлбэрээр сан хөмрөгт цуглуулдаг. Завхан аймгийн Нөмрөг суманд Булгийн эх гэдэг газраас илэрсэн олдворуудыг музейд бүртгэн авсан бөгөөд музейн үзмэрийн тоо өмнөх оноос 102-оор, мөн бэлэг, хандиваар Сүхбаатар аймгийн музейд 160 үзмэр, Баянхонгор аймгийн музейд 70 үзмэр, Өвөрхангай аймгийн музейд 121 үзмэр тус тус нэмэгдсэн. /Музейн үзмэрийн тоог 1,000-д харьцуулан бодож гаргасан. Музейн үзмэрийн тоо-249,727/

7.3 НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮН, ЗАРДЛЫН ӨГӨӨЖ

Нийслэл Улаанбаатар хотод Үндэсний номын сан, Хүүхдийн төв номын сан гэсэн төрийн өмчит 2 номын сан байгаа бол дүүрэг болон аймгуудад орон нутгийн өмчит нийт 23 номын сан улсын төсвөөс санхүүжилт авч байна. Түүнчлэн сум, дүүргийн соёлын төвүүдэд жижиг номын сан ажилладаг ба эдгээрийг оролцуулан тооцвол нийтдээ 362 номын сан үйл ажиллагаа эрхэлж байна. Номын сангийн уншигчдын тоо 2012-2018 оны хооронд тогтмол байсан бол 2019 онд 388,180 болж нэмэгдсэн байна. Гэхдээ уншигчдын тоо цар тахлын нөлөөгөөр 2021 онд 2 дахин буурч 191,348 болсон бол 2022 онд 306,281, 2023 онд 286,447 болж өмнөх оны түвшнээс 19,834-өөр буурсан байна.

График 7. Номын сан, фонд





График 8. Уншигчдын тоо, суудлын тоо



Төрийн ба орон нутгийн өмчит 25 номын сангийн үйл ажиллагааны урсгал зардал, үндсэн үйл ажиллагаанаас олсон өөрийн орлогын хэмжээг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 15. Номын сангийн зардлын өгөөж

Үзүүлэлт	Уншигчдын тоо (мянган хүн)	Нийт урсгал зардал (сая төг.)	Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого (сая төг.)	1 уншигчид ногдох үйл ажиллагааны зардал (төгрөг)	100 төгрөгийн зардалд ногдох өөрийн орлого (төгрөг)
2022 он	306.3	7,524.0	80.2	24,564	2
2023 он. Үүнээс:	286.4	14,159.0	196.0	49,438	1
Орон нутгийн өмчит номын сан		9,158.8	113.7		1
Төрийн өмчит номын сан		5,000.3	82.3		2

Ковидын нөхцөл байдлаас өмнө 2013-2018 онд номын сангууд (соёлын төвд байрших номын сан, өрөөг оруулахгүйгээр) жилдээ 30-40 сая төгрөгийн орлого олдог байсан бол 2022 онд 80.2 сая төгрөг, 2023 онд 196.0 сая төгрөг болж 2 дахин орлого нь нэмэгдсэн байна. 2022 онд номын сангийн 1 байнгын уншигчид ногдох үйл ажиллагааны дундаж зардал 24.6 мянган төгрөг байсан бөгөөд 100 төгрөгийн зардалд 2 төгрөгийн орлого олжээ. Энэ үзүүлэлт 2023 онд 1 уншигчид ногдох үйл ажиллагааны зардал 49.4 мянган төгрөг болж нэмэгдсэн бол 100 төгрөгийн зардалд олох орлого 1 төгрөг болж буурсан байна.

Номын сангийн үйлчилгээг нь иргэдэд үнэ төлбөргүй үзүүлдэг учраас үндсэн үйл ажиллагааныхаа хүрээнд орлого олох боломж бараг үгүй юм.

Харин орон нутгийн өмчит номын сангийн 100 төгрөг тутамд олох орлого 1 төгрөг бол төрийн өмчит номын сангийн 100 төгрөгийн зарлага тутамд олох орлого 2 төгрөг байна.

Харин номын сангийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, номын сангаар цахимаар зайнаас үйлчлүүлэх боломжийг үйлчлүүлэгчдэд хангах чиглэлээр ажиллах нь хүн амын боловсрол, соёл, хөгжилд үр дүнтэй хувь нэмэр болно.

Номын сангийн үйл ажиллагаатай холбоотой үзүүлэлтийн биелэлт:

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн нэгдүгээр хавсралтаар номын сангийн үйл ажиллагаатай холбоотой дараах 2 үзүүлэлт батлагдсан байна.

1. “33.1.2-Нийтийн номын сангийн байнгын уншигчдын хүн амд эзлэх хувь” үзүүлэлтийн хувьд зорилтот түвшнээс 5.3 нэгжээр бага буюу 9.7%-д хүрч гүйцэтгэл 65%-тай байна.
2. “33.1.2-10,000 хүнд ногдох номын тоо /ширхэг/” үзүүлэлтийн хувьд зорилтот түвшнээс 9,456.9-өөр бага буюу 18,543.1-д хүрч гүйцэтгэл 66.2%-тай байна.

Номын сангийн үйл ажиллагаатай холбоотой тоон болон чанарын үзүүлэлт биелээгүй байна.

Хүснэгт 16. Номын сангийн үзүүлэлтийн биелэлт

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт			Суурь он	Суурь түвшин	2023 оны зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэлийн хувь
33.1	Соёл урлаг						
	33.1.2	Нийтийн номын сангийн байнгын уншигчдын хүн амд эзлэх хувь	2021	6.5	15	9.7	65%
	33.1.5	10,000 хүнд ногдох номын тоо /ширхэг/	2021	19,000	28,000	18,543.1	66.2%

33.1.2. Нийтийн номын сангийн байнгын уншигчдын хүн амд эзлэх хувь

Улсын хэмжээний байнгын уншигчийн тоо 286,447 байгаа нь 6-аас дээш насны хүн амын 9.7 хувийг эзэлж байна.

Тооцох аргачлал: /Байнгын уншигчийн тоог 6-аас дээш насны хүн амын тоонд харьцуулан 100-аар үржүүлж бодож гаргасан. Байнгын уншигчийн тоо-286,447/

33.1.5. 10,000 хүнд ногдох номын тоо /ширхэг/


Улсын хэмжээнд номын сангийн сан хөмрөгт нийт 6,272,595 ном байгааг 10 мянган хүнд ногдохоор тооцоход 18,540 ном байна. Энэ нь 2022 оны үзүүлэлт 18,560 байгаагаас 90-ээр буурсан байна. 2022 онд номын сан хөмрөгийн тоо 6,252,516 байсан бол 20,079 номоор нэмэгдсэн хэдий ч хүн амын тоо 28,156-аар өссөн учраас буурсан үзүүлэлттэй байна.

Тооцох аргачлал: /Номын сан хөмрөгийн тоог хүн амын нийт тоонд харьцуулан 10000-аар үржүүлж 1000-д хуваасан. Номын сан хөмрөгийн тоо-6,272,595/

7.4 СОЁЛЫН ТӨВИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮР ДҮН, ЗАРДЛЫН ӨГӨӨЖ

Манай улсад 2012-2021 онд төр ба хувийн хэвшлийн 341-347 соёлын төв, ордон, өргөө байжээ. Харин соёлын төвийн ажилтны тоо 2017 онд хамгийн бага буюу 2,339 хүн байсан бол 2023 онд 2,453 хүн болж 13% -аар нэмэгдсэн байна.

График 9. Соёлын төвийн үзүүлэлт



2023 оны эхний хагас жилийн байдлаар орон нутгийн өмчит 344 соёлын төв байгаагаас 334 нь сумын соёлын төвүүд, 7 нь дүүргийн соёлын төвүүд болон Хүүхдийн урлан бүтээх төв, Соёлын төв өргөө, Хүүхдийн ордон байна. Эдгээр 344 соёлын төв, ордонд 2023 оны 6 дугаар сарын байдлаар 2,399 хүн ажиллаж байна.⁷

Соёлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “25.2.Сум, дүүргийн соёлын төв, соёлын ордон нь тухайн орон нутгийн иргэний соёлын үйл ажиллагаа эрхлэх, бүтээл туурвих, соёлын ололт, үр шимийг хүртэх нөхцөлийг хангах, орон нутгийн байгаль, түүх, соёлын үнэт зүйлийг сурталчлах, номын сангийн үйлчилгээ хүргэх чиг үүрэгтэй соёлын боловсрол олгох анхан шатны байгууллага бөгөөд соёл, мэдээллийн төв байна.” гэж заасан.

Соёлын төвүүд нь улсын ба орон нутгийн төсвөөс санхүүжилт авдаг тухай энэ тайлангийн өмнөх бүлгүүдэд дурдсан. 2022 онд Соёлын сайдын төсвийн багцын урсгал шилжүүлгээс соёлын төвүүдийн урсгал зардалд 30.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна. 2012-2023 онд соёлын төвд ажиллагчдын тоо төдийлөн нэмэгдээгүй байна.

⁷ Соёлын яамнаас 2023 оны 7 дугаар сард авсан тоо мэдээ.

Соёлын төвүүдийн 1 суудалд ногдох жилийн үйл ажиллагааны зардал 2013-2018 оны дунджаар 460 мянган төгрөг, 2022 онд 343.4 мянган төгрөг, 2023 онд 796.7 мянга болж нэмэгдсэн байна. Энэ нь театр, чуулга, музейн нэг үйлчлүүлэгчид болон номын сангийн 1 уншигчид ногдох жилийн үйл ажиллагааны зардлаас өндөр байна. Сумын соёлын төвөөр үйлчлүүлсэн хүний тооны албан ёсны статистик мэдээллийг нийтэд зарладаггүй учраас 1 үйлчлүүлэгчид ногдох зардлыг тооцох боломжгүй байна. Сумын соёлын төвүүд нь соёлын үйлчилгээнүүд дотроос хамгийн өндөр өртөгтэй үйлчилгээ байх магадлалтай байна. Хэдийгээр зардлын хувьд өртөгтэй ч хүн амд соёлын үйлчилгээг түгээх анхан шатны нэгж учраас зайлшгүй байх шаардлагатай билээ.

Үзүүлэлт	Суудлын тоо (мянган хүн)	Нийт урсгал зардал (сая төг.)	Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого (сая төг.)	1 суудалд ногдох үйл ажиллагааны зардал (төгрөг)	100 төгрөгийн зардалд ногдох өөрийн орлого (төгрөг)
2023 он.	90.4	72,024.1	952.3	49,438	1

Соёлын төвийн үйл ажиллагаатай холбоотой үзүүлэлтийн биелэлт:

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн нэгдүгээр хавсралтаар соёлын төвийн үйл ажиллагаатай холбоотой дараах 1 үзүүлэлт батлагдсан байна.

1. “33.1.6-10,000 хүнд ногдох соёлын төвийн суудлын тоо” үзүүлэлтийн хувьд зорилтот түвшнээс 37-оор бага буюу 263-д хүрч гүйцэтгэл 87.7%-тай байна.

Соёлын төвийн үйл ажиллагаатай холбоотой тоон болон чанарын үзүүлэлт биелээгүй байна.

Хүснэгт 17. Соёлын төвийн үзүүлэлтийн биелэлт

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт			Суурь он	Суурь түвшин	2023 оны зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэлийн хувь
33.1	33.1.6	10,000 хүнд ногдох соёлын төвийн суудлын тоо	2021	279	300	263	87.7%

Нийт соёлын төв, соёлын ордны суудлын тоо 89,350 бөгөөд 10,000 хүн тутамд 263 суудал ногдож байна. 2022 онд 10,000 хүн тутамд ногдох соёлын төв, соёлын ордны суудлын тоо 269 байснаас 6-аар буурсан. Хөвсгөл аймгийн Ханх болон Галт сумын соёлын төвүүд шатсантай холбоотой буурсан байна.

Тооцох аргачлал: /Номын сан хөмрөгийн тоог хүн амын нийт тоонд харьцуулан 10,000-аар үржүүлж 1,000-д хуваасан. Номын сан хөмрөгийн тоо-6,272,595/

7.5 СОЁЛЫН САЛБАРЫН БУСАД ТООН БОЛОН ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

Хүснэгт 18. Салбарын бусад үзүүлэлтийн биелэлт

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт		Суурь он	Суурь түвшин	2023 оны зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэлийн хувь	
33.1	Соёл урлаг						
	33.1.1	Соёл урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчийн хүн амд эзлэх хувь	2021	75	78	285.2	365.6%
	33.1.7	Улсын хэмжээнд хэрэгжүүлсэн үндэсний хөтөлбөрийн тоо	2021	5	21	21	100.0%

Соёлын сайдын чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн хэрэгжилтийг шалгуур үзүүлэлт тус бүрээр авч үзсэн.⁸

33.1.1. Соёл урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчийн хүн амд эзлэх хувь

Тухайн үзүүлэлтийн хувьд зорилтот түвшнээс 207.2 нэгжээр их буюу 285%-д хүрч гүйцэтгэл 365.6%-тай байна.

Соёл, урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчдийн нийт тоо 12,340,849 (үүнд урлагийн байгууллагын үзэгчийн тоо 1,502,315; музейн үзэгчийн тоо 1,158,176; соёлын төвийн номын сангийн үйлчлүүлэгчдийн тоо 2,980,022; соёлын төв, соёлын ордноор үйлчлүүлэгчдийн тоо 3,527,318; кино үзвэр үзэгчийн тоо 3,173,018) байгаа нь Монгол Улсын хүн амын нэг хүнд ногдох соёл, урлагийн байгууллагын үйлчилгээ 3.6 дахин буюу нэг хүн давхардсан тоогоор 3.6 удаа соёл, урлагийн үзвэр, үйлчилгээг үзсэн байна.

Тооцох аргачлал: Нийт соёл урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчдийн тоог суурин хүн амын дундаж тоонд харьцуулан 100-аар үржүүлэн бодож гаргасан. /2023 оны хүн амын тоо-3,396,788/

Тухайн үзүүлэлт биелсэн байна.

33.1.7. Улсын хэмжээнд хэрэгжүүлсэн үндэсний хөтөлбөрийн тоо

Тухайн үзүүлэлтийн хувьд зорилтот түвшинтэй ижил буюу 21-д хүрч гүйцэтгэл 100%-тай байна.

2023 онд дараах 21 үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.

1. Соёлын бүтээлч үйлдвэрлэл
2. Бүх нийтийн соёлын боловсрол
3. Цахим соёл арга хэмжээ
4. Монгол өв ба дэлхий дахинд арга хэмжээ
5. Уран бүтээл хийлгэх арга хэмжээ
6. Эрдэм шинжилгээ, судалгааны ажил
7. Ахмад дайчин, алдар цолтой ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламж

⁸ Эх үүсвэр: Соёлын яам

-
8. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт
 9. Соёл урлаг хөгжүүлэх
 10. Музейн үзмэр худалдан авах
 11. Түүхийн хүрд баримтат кино бүтээх
 12. Түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах
 13. Музей, түүх, соёлын өвийн сэргээн засварлалт
 14. Хөгжмийн шилдэг бүтээлийг улсын санд худалдаж авах
 15. Дүрслэх урлагийн шилдэг бүтээлийг улсын санд худалдаж авах
 16. Соёл урлагийн олон улсын тэмцээнд тэргүүн байр эзэлсэн уран бүтээлчдийг шагнах
 17. Оны шилдэг уран бүтээлч найруулагч жүжигчин зураач бүжигчдийг шагнах
 18. Гадаад дотоодод зохиогдох соёл урлагийн арга хэмжээ
 19. Кино урлагийг дэмжих
 20. Монгол Улсын Олон улс дахь сурталчилгаа, мэдээллийн үндэсний хорооны үйл ажиллагааны хэрэгжилт
 21. Үндэсний соёлын нэгдмэл үнэт зүйлийн стратеги, төлөвлөгөө, Мэргэжлийн урлагийн байгууллагыг хөгжүүлэх арга хэмжээ


Тухайн үзүүлэлт биелсэн байна.

8. ТӨСВИЙН ХАНГАЛТТАЙ БАЙДАЛ

Соёлын салбар 2023 оны байдлаар 33.4 тэрбум төгрөгийн авлагатай болсон нь 2022 онтой харьцуулахад 729.5 сая төгрөгөөр буурсан байна. Нийт авлагын 90.0% буюу 30.0 тэрбум төгрөг нь салбарын хөрөнгө оруулалт, их засварын дансанд бүртгэгдсэн байна. Бусад харьяа байгууллагад нийт 3.4 тэрбум төгрөгийн авлагатай гарсан үзүүлэлттэй байна.

Нийт өр төлбөрийн хувьд 2023 оны гүйцэтгэлээр 32.2 тэрбум төгрөгийн өр төлбөртэй гарсан бөгөөд энэ нь өмнөх онтой харьцуулахад 8.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлт юм. Энэ нь тухайн салбарын барьцаа хөрөнгө/хөрөнгө оруулалт/-ийн дансанд нийт 31.1 тэрбум төгрөгийн өр төлбөртэй гарсан нь нийт өр төлбөрийн 96.6% болж байна.

График 10. Салбарын нийт авлага, өр төлбөр⁹ /сая.төг/



Эх үүсвэр. Соёлын яам, 2024

Нийт авлагын 90 хувь, нийт өр төлбөрийн 96 хувь нь салбарын хөрөнгө оруулалт, их засварын болон барьцаа хөрөнгийн гэсэн 2 дансанд байршиж байгаа нь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсвийг оны эцэст эдгээр дансанд төвлөрүүлэн төсвийн дараа жил рүү шилжүүлж, барилгын гүйцэтгэл дууссаны дараа санхүүжүүлдэгтэй холбоотой байна.

Нийт авлага, өр төлбөрийн хэмжээг 2023 оны байдлаар төсвийн төрөл, хөтөлбөр, гарцаар доорх хүснэгт харуулав.

⁹ Салбарын санхүүгийн байдлын тайлангийн эцсийн гүйцэтгэл үзүүлэлтийг ашигласан болно.

Хүснэгт 19. Нийт авлага, өр төлбөр /сая.төг/

Хөтөлбөр, гарц	Нийт авлага		Нийт өр төлбөр	
	Байгууллага	Эцсийн үлдэгдэл	Байгууллага	Эцсийн үлдэгдэл
Орон нутаг	167	305.0	169	994.8
Соёл урлаг	159	259.8	163	970.7
Номын сангийн үйлчилгээ	9	43.1	11	19.2
Соёлын төвийн үйлчилгээ	135	76.4	139	650.0
Театр, чуулгын үйлчилгээ	15	140.4	13	301.6
Соёлын өв	8	45.2	6	24.1
Музейн үйлчилгээ	8	45.2	6	24.1
Улсын төсөв	32	33,052.7	25	31,217.6
Соёл урлаг	8	30,427.0	7	31,160.7
Номын сангийн үйлчилгээ	2	314.0	2	25.8
Соёл урлагийн хөрөнгө оруулалт	1	30,015.2	1	31,131.5
Театр, чуулгын үйлчилгээ	5	97.9	4	3.4
Соёл урлаг, спорт, аялал жуулчлалын бодлого, удирдлага	11	118.6	12	46.4
Засаглал, эрх зүйн орчныг сайжруулах	1	-	1	1.2
Хэрэгжилт, зохицуулалтыг хангуулах	10	118.6	11	45.2
Соёлын бүтээлч үйлдвэрлэл	2	25.0	1	2.9
Кино урлагийн үйлчилгээ	2	25.0	1	2.9
Соёлын өв	11	2,482.1	5	7.8
Музейн үйлчилгээ	9	2,423.7	4	7.8
Соёлын биет болон биет бус өвийн хамгаалал	1	58.3	1	-
хөгжил, сурталчилгааны үйлчилгээ				
Соёлын өвийн эрдэм шинжилгээ, судалгааны үйлчилгээ	1	-		
НИЙТ ДҮН	199	33,357.7	194	32,212.4

Эх үүсвэр. Соёлын яам, 2024

Салбарын 2023 оны төсвийн гүйцэтгэлээр орон нутгийн 167 (өмнөх оноос 42 байгууллага нэмэгдсэн) байгууллагын нийт авлага 305.0 сая төгрөг, нийт өр төлбөр орон нутгийн 169 (өмнөх оноос 45 байгууллага нэмэгдсэн) байгууллагад 994.8 сая төгрөг байна.

Харин соёлын сайдын шууд харьяа байгууллагын нийт авлага 33.1 тэрбум төгрөг (32 байгууллага), нийт өр төлбөр 31.2 тэрбум төгрөг (25 байгууллага) байна.

9. ДҮГНЭЛТ

- Салбарын нийт төсвийн ДНБ-д эзлэх хувь 2022 онд 0.3% байсан бол 2023 онд 0.4% болж 1.0 нэгжээр, улсын нэгдсэн төсвийн зарлагад эзлэх хувь 2022 онд 1.0% байсан бол 2023 онд 1.4% болж 0.4 нэгжээр нэмэгдсэн сайн үзүүлэлттэй байна.
- Төсвийн нийт гүйцэтгэл 98.3 хувийн гүйцэтгэлтэй байна.
- Төсвийг батлахдаа хөтөлбөр, түүний үйл ажиллагааны чиглэлтэй уялдуулсан гарцтай хамааруулж төлөвлөөгүй тул төсвийн гүйцэтгэлийг шалгуур үзүүлэлттэй уялдуулж тус бүрээр нь үр ашгийг тооцох боломжгүй байна.
- Салбарын хэмжээнд Хөтөлбөрийн үр дүнгийн чанарын ба тоон шалгуур 8 үзүүлэлт батлагдсан бөгөөд үүнээс 4 үзүүлэлт биелж, 4 үзүүлэлт биелээгүй байна. Үүнд:
 - Мэргэжлийн урлагийн байгууллагын чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт биелээгүй байна.
 - a. Мэргэжлийн урлагийн байгууллагын үзэгчдийн давхардсан тоо /сая хүн/, гүйцэтгэл 41.7%
 - Музейн үйл ажиллагаатай холбоотой тоон болон чанарын 2 үзүүлэлт биелсэн байна.
 - a. Музейн үзэгчдийн хүн амд эзлэх хувь, гүйцэтгэл 185.7%
 - b. Жилийн эцэст хүрсэн байх музейн үзмэрийн тоо /мянгаар/, гүйцэтгэл 101.9%
 - Номын сангийн үйл ажиллагаатай холбоотой тоон болон чанарын 2 үзүүлэлт биелээгүй байна.
 - a. Нийтийн номын сангийн байнгын уншигчдын хүн амд эзлэх хувь, гүйцэтгэл 65.0%
 - b. 10,000 хүнд ногдох номын тоо /ширхэг/, гүйцэтгэл 66.2%
 - Соёлын төвийн үйл ажиллагаатай холбоотой тоон болон чанарын үзүүлэлт биелээгүй байна.
 - a. 10,000 хүнд ногдох соёлын төвийн суудлын тоо, гүйцэтгэл 87.7%
 - Улсын хэмжээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаатай холбоотой тоон болон чанарын 2 үзүүлэлт биелсэн байна.
 - a. Улсын хэмжээнд хэрэгжүүлсэн үндэсний хөтөлбөрийн тоо, гүйцэтгэл 100%
 - b. Соёл урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчийн хүн амд эзлэх хувь, гүйцэтгэл 365.5%

10. ЗӨВЛӨМЖ

- Салбарын төсөв 2022 оны түвшнээс 139.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэн 316.9 тэрбум төгрөгөөр батлагдаж, төсвийн гүйцэтгэл 311.7 тэрбум буюу 98.3 хувьтай байгаа хэдий ч хөтөлбөрийн үр дүнгийн чанарын ба тоон шалгуур үзүүлэлтийн биелэлт 50 хувьтай байгаа тул зардлын хуваарилалтыг салбарын үйл ажиллагааны чиглэл буюу гарцтай уялдуулж оновчтой төлөвлөх;
- Хөтөлбөрийн үр дүнгийн чанарын ба тоон шалгуур үзүүлэлтийг Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан үр дүн, түүнийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг хэрэглэж батлагдсан төсөвтэй уялдуулан төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

